

**“НИЙСЛЭЛ ОРЧМЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ”
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2016оны жилийн эцсийн байдлаар/

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1	НИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах,хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилго: Хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэхэд хадлан бэлчээрийн талбайн ургамлын нөмрөгт цөлжилтийн даацыг даахуйц, орчны таатай уур амьсгал бүрэлүүлэх, хөрс цаг уурын нөхцөлд тохирсон ургах чадвар өндөр ногоон масс ихтэй тэжээлийн ургамлыг нутагшуулж, малчид, фермерүүдийн идэвхи оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежментийг шинэчлэхэд чиглэгдэнэ.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Нийслэлийн төсөв			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа/	НХХААГазар 1-р үе шаттай 2015-2020 онуудад хэрэгжинэ.			
4.	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1 Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент,дэвшилтэт технологи нэвтрүүлэх. Зорилт 2. Малчид, фермерүүдийн хоршоодыг байгуулах. Зорилт 3. Хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллуулах Зорилт 4."Техник дундын үйлчилгээний төв"-ийг бий болгох			
5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/	2.813.000.000		
		Үүнд:	Төсөв /2016 он/	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1 90 үнээний зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуй байгуулах	1 241 200 000	887 655 999	95
		Багц 2 Худаг /2 ширхэг/	64 956 897	59 900 898	100
		Багц 3 Цахилгаан хангамж	60 025 862	59 897 021	100
		Багц 4 Зам харгуй, фермийн дотоод тохижилт	55 000 000	49 992 218	100
		Багц 5 Тэжээлийн талбай хаших хайсны зардал	100 000 000	88 270 830	100
		Багц 6 Хадлан, тэжээл техник тоног төхөөрөмж	919 759 360	917 600 000	100
	Багц 7 Бага оврын газар тариалангийн техник, тоног төхөөрөмж	332 040 640	Монгол улсын засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр тухайн өдрөөс хойш тендер, худалдан авалтыг зогсоосон.	0	

Хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлт
<p>1-р зорилтын хүрээнд:</p> <p>1.1.Бэлчээрийг нөхөн сэргээхэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орон нутгийн хөрс,цаг уурын нөхцөлд тохирсон шинэ сортын ногоон тэжээлийн таримлыг нутагшуулан тариалалтыг хийлгүүлнэ.</p> <p>1.2.Малын бүтэн жилийн хэрэгцээний ногоон тэжээлийг бий болгоно.</p> <p>1.3.Аж ахуйн талбайд хаягдмал хур өтөг, бууцыг 1 га талбайд 10-15м³ орох нормоор түлхүү хэрэглэн, бэлчээрийн талбайг бордож1 га-с авах ургацыг 2000кг хуурай массад хүргэнэ.</p> <p>1.4.Тариалангийн болон тэжээл тариалах талбайг аль болох бага хөдөлгөн үржил шимийг хадгалж, талбайг хагалахгүйгээр үрлэж тариалах технологийг нэвтрүүлнэ.</p> <p>1.5.Ногоон тэжээлийг шинэ технологгоор тариалж, хоршооны үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүнийг бий болгоно.</p> <p>1.6.Хөрсний агрохимийн бүтцийн өөрчлөлтөнд онцгой анхаарч, бордох тунг хөрс байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар тохируулж бордоно.</p> <p>1.7.Шинэ технологгоор тариалж үйлдвэрлэсэн тэжээлийг /дарш/ хөтөлбөрт хамрагдсан хоршооны мал сүрэгт /саалийн үнээ,хонь,ямаа/ ашиг шимийн судалгааны зориулалтаар ашиглана.</p>	<p>1.1 150га хашаандаа эхний ээлжийн туршилтын 10га газарт 2016 оны 07 сарын 07-08-ны өдрүүдэд тэжээлийн олон наст таримлын холимогоор үрлэгээ хийсэн. /Нийт 6-н төрлийн таримал ургамлын үрийн холимог/</p> <p>1.2 Үрэлгээний техник тариалалтын хугацаанаас хоцорч ирсэн тул шинэ дэвшилтэт технологийг 10га газарт туршилтаар тариалсан. Олон наст холимог ургамал эхний жилдээ 18-20см өндөртэй өвөлжилтийн тайван байдалд шилжсэн ба ногоон тэжээл хураан аваагүй болно.</p> <p>1.3 Фермийн аж ахуйн барилга байгууламжийн гүйцэтгэлийн ажил 97%-тай хийгдэж дуусгасан. Уг ажлыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүлээж авахаар болсон. Өтөг бууц цацах тоног төхөөрөмжийг 2016 оны 09 дүгээр сарын 28-нд хүлээн авч цаашид хаягдмал хур өтөг, бууц хэрэглэх төлөвлөгөөг гаргасан.</p> <p>1.4 10 га талбайд 2016 оны 07 сард олон наст холимог үрийг агротехнологийн дагуу хагалж услахгүйгээр тариалалтыг хийн 09 дүгээр сарыг хүртэл ажиглалт судалгааг хийсэн. Үр дүн нь нэгж тайлбайгаас авах ургацын хэмжээ нэмэгдэх боломжтой.</p> <p>1.5 “Бэлчээрийн менежмент” төслийн нэгж ОНӨТҮГ нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дугаар тотоолоор байгуулагдаж хөтөлбөрийн хэрэгжилтийг цаашид хангаж ажиллахаар болсон. Үүнтэй холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнг тус төслийн нэгж хариуцан ажиллаж байгаа.</p> <p>1.6 Монгол орны бэлчээрийн хөрсний шинжилгээний дээжийг авч Австрийн Эрдэм Шинжилгээний Хүрээлэнд шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс хамаарч бордох тунг нормыг Австрийн эрдэмтэн К.Бухграбер тогтоосон. /га-д 200кг-аар эрдэс бордоо болон бууцан бордоогоор бордох зөвлөмж ирсэн./</p> <p>1.7 Шинэ технологиор тэжээл /дарш/ бэлтгэх аргыг судлан төлөвлөгөө боловсруулсан. /эхний шат/ Техникийг нь 2016 оны 11 сард хүлээж авсан. 2017 онд үр дүн нь тодорхой болно.</p>

<p>1.8.Шинэ сортын ногоон тэжээлийг зах зээлд өрсөлдөх чадвартайгаар нийлүүлнэ.</p>	<p>1.8 Зах зээлд өрсөлдөх чадвартай ногоон тэжээл бэлтгэнэ /эхний шат/.</p>
<p>1.9.Уламжлалт аргаар боловсруулсан нийлмэл хольцтой/дарш/ тэжээлийг бүрэн орлохуйц тэжээлийн орц найрлага нь стандартын биологийн өндөр ашиг шимтэй,экологийн цэвэр,тэжээлийн чанарыг алдагдуулахгүй савлагаа боодол бүхий овор хэмжээ багатай,хадгалалтыг даах чадвартай ашиг шим өндөртэй бүтээгдхүүнийг тариалж үйлдвэрлэнэ.</p>	<p>1.9 Таримал хадлан бэлчээрийн шим тэжээлийг алдагдуулахгүйгээр дэвшилтэт тоног төхөөрөмжийг ашиглан хаман боож, дарш болгон битүүмжлэн технологийн горимын дагуу хадгалах технологийг 2017 онд хэрэгжүүлнэ. 2017 онд хийхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p>
<p>1.10.Улаанбаатар орчимд ойролцоогоор нэг үнээнээс саалийн хугацаанд 2000л сүү сааж байгааг чанартай тэжээл өгснөөр 4000л болгох бололцоотой болно.</p>	<p>1.10 Тэжээлийн болон саалийн үнээний үүлдэр, сүүний гарцыг сайжруулах тэжээлийг шинээр бий болгох ажлыг бэлэн болгоод байна.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: 2.1. Малчид, фермерүүдийг өрхийн жижиг аж ахуйгаас татгалзуулан нэгдсэн зохион байгуулалтанд оруулж хоршоод болгоно.</p>	<p>2.1 Өрхийн фермер, ААН, иргэдийг хоршоо байгуулах нэгдсэн сургалтанд хамруулах, судалгааг хийж байна.</p>
<p>2.2. Хоршоодыг “Хоршооны тухай” хуулийн дагуу эрх зүйн баримт бичгээр баталгаажуулна.</p>	<p>2.2 Хоршоо байгуулах болон тэжээл бэлтгэх судалгаанд малчдыг хамруулах ажлыг зохион байгуулахаар байна.</p>
<p>2.3. Хоршоодыг шаталсан сургалтаар чадавхижуулна.</p>	<p>2.3 Мэргэжлийн анхан болон гүнзгийрүүлсэн шатны сургалт, семинарийг Австрийн эрдэмтэдтэй хамтран зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж байна.</p>
<p>2.4. Гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын аль ч дамжлагад стандарт, эрүүл ахуйн шаардлагыг чанд баримтлана.</p>	<p>2.4 Холимог тэжээл үйлдвэрлэлээр бий болсон бүтээгдэхүүн /дарш/-ийг Итгэмжлэгдсэн лаборторит шинжлүүлэн гарал үүслийг баримтжуулахын тулд НМХГ-тай хамтран ажиллахаар 2017 онд төлөвлөсөн.</p>
<p>2.5. Малчид, фермерүүд биологийн чанар өндөртэй, ашиг шимийн гарц сайтай</p>	<p>2.5 Малчид, фермерүүдэд сургалт, семинар явуулж улмаар дадлагажуулан заавар зөвөлгөө өгснөөр шинэ техник технологи бүхий сайн чанарын тэжээл үйлдвэрлэл</p>

<p>сайжруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийцэхүйц өрсөлдөх чадавхитай болно.</p>	<p>Монгол оронд нэвтэрч зах зээлд нийцэхүйц өрсөлдөх чадвартай болно.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p>	
<p>3.1. Хоршоо, иргэний тэжээл тариалах талбайг “сайн, дунд, бага” гэсэн 3 ангиллаар ангилна.</p>	<p>3.1 Талбайн хөрсний шинж чанар болон ургамлын төрөл, зүйлээс хамаараад “сайн, дунд, бага” гэсэн 3 ангилалд хуваагдах ба үүнтэй холбоотой заавар зөвлөмж боловсруулан зөвлөгөө өгөх ажлыг цаашид зохион байгуулна.</p>
<p>3.2. Шинээр байгуулагдах загвар аж ахуй нь “Монголын фермер өрхийн загвар аж ахуй” болно.</p>	<p>3.2 Австрийн эрчимжсэн фермерийн аж ахуйн дэвшилтэт технологийг цогцоор нь нэвтрүүлж улмаар “Монголын фермер өрхийн загвар аж ахуй” болгох зорилт тавин ажиллаж байна.</p>
<p>3.3. Загвар аж ахуй нь ажилчдын сууц, сургалтын байр, сургуулийн дотуур байр, малын байр /саалийн үнээ, үржлийн үнээ, бог ба адуу/ машин механизмын гараж, засварын газар зэргээс бүрдэх ба шинээр барьж байгуулна.</p>	<p>3.3 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны "Нийслэлийн 2015 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 24/04 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх” тухай 2015 оны А/631 дугаар захирамжийн дагуу Газрын даргын 2015.09.10-ны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй“ 90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах” НҮХААГ-16/001 тоот тендерийн ажлын явц 97%-тай байгаа бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүлээж авах техникийн комисс ажиллахыг хойшлуулаад байна.</p>
<p>3.4. Загвар аж ахуй нь дэд бүтцээр бүрэн хангагдсан байна.</p>	<p>3.4“Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутагт Бэлчээрийн менежментийг сайжруулах төслийн газарт 63квчадалтай 10/0,4кВ-ын трансформаторбүхий КТПН шинээр барих” /дугаар НҮХААГ-15/0008/ тоот тендерийг “Эрчим-Өгий” ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр техникийн комисс хүлээн авсан Одоогоор агаараар цахилгааны шугам татах ажил дууссан боловч фермийн барилгын байрлалыг өөрчилсөнтэй холбогдоод 520м цахилгааны утсыг агаараар татах ажлыг хийх шаардлагатай байна.</p>
<p>3.5. Загвар аж ахуй нь 30 гаруй саалийн үнээний өтөг зайлуулах ба цахилгаан саалтуурын систем бүхий хөргөлтийн байгууламжийг барьж байгуулна.</p>	<p>3.5 Турк улсад үйлдвэрлсэн өдөрт 90 үнээ саах хөргөлтийн систем бүхий цахилгаан саалтуурыг хүлээн аваад байна.</p>
<p>3.6. Хаягдлыг урсган гадагшлуулан, хадгалах 500м3 багтаамжтай агуулахтай байна.</p>	<p>3.6 Тендерийн хүрээнд 500м3 багтаамжтай шивх хадгалах савтай болсон.</p>
<p>3.7. Загвар аж ахуй нь дэргэдээ сургалтын байрыг</p>	<p>3.7 “90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах” НҮХААГ-16/001 тоот</p>

<p>байгуулах ба сургалт, зөвлөгөө, судалгааны ажил үйлчилгээ болон өдөрлөг бусад арга хэмжээ явагдана.</p>	<p>тендерийн ажлын явц 97%-тай байгаа бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүлээж авах техникийн комисс ажиллахыг хойшлуулаад байна.</p>
<p>4-р зорилтын хүрээнд: 4.1. Ногоон тэжээлийн талбайд зориулалтын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг ашиглана.</p>	<p>4.1 Багаоврынтракторболон ХАА-н машин, тоног, төхөөрөмж” худалданавах НҮХААГ-15/03 тоот тендер шалгаруулалтыг 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдөр дахин зарлаж 2ажахуйннэгжматериал ирүүлснээс “Хаш техник” ХХК шалгарсан. Гэвч Монгол улсын засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сарын 17-ноос хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй, гэрээ байгуулахгүй байхаар холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасны дагуу тендерийг цуцалсан. “Хөдөө аж ахуйн дунд оврын трактор хадлангийн тоног төхөөрөмж нийлүүлэх” НҮХААГ-15/02 дугаар бүхий тендерийг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулж 110 морины хүчин чадалтай 2 ширхэг трактор болон үлдсэн техникүүдийг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ний А/18 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүлээн авлаа.</p>
<p>4.2.Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг хоршоод болон техник тоног төхөөрөмж дутагдалтай байгаа иргэн,аж ахуйн нэгжид түрээсийн үйлчилгээг үзүүлэх болонлизингээр тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.</p>	<p>4.2 Итали, Турк, Германы дэвшилтэт техник тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч фермерийн аж ахуй эрхэлдэг хоршоод, иргэд, ААН-үүдэд хөнгөлөлттэй нөхцлөөр түрээсийн үйлчилгээ үзүүлэх боломжийг судлан, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаар төлөвлөөд байна.</p>
<p>4.3.”Техник дундын төв”-ийг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг НҮХААГазар хариуцаж ажиллана.</p>	<p>4.3 Бэлчээрийн менежментийн төслийн нэгж нь удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.</p>
<p>4.4.Орон нутгийн иргэн,аж ахуйн нэгж,хоршоодод хөдөө аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд мэргэшсэн мэргэжилтэн зөвлөх үйлчилгээг үзүүлж, эрсдэлгүй ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.</p>	<p>4.4 “Бэлчээрийн менежмент” төслийн нэгж ОНӨТҮГ байгуулах ажил мөн зарим тендерийн шалгаруулалтай холбогдсон гомдол гарсан зэргээс хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлууд хойшлогдсон тул 2017 оноос эхлэн тухайн ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага бий болсон.</p>
<p>4.5. Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төвийг ажиллуулна.</p>	<p>4.5Түлхүүр гардуулах нөхцөлтэй “90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах” НҮХААГ-16/001 тоот тендерийн ажлын явц 90%-тай байгаа бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүлээж авах техникийн комисс ажиллахыг хойшлуулаад байна. Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаа эхлээгүй байна.</p>

	<p>4.6.Шинэ дэвшилтэт хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг хот орчмын аж ахуй нэгж,иргэдэд сурталчилж,мэдээ мэдээллээр ханган эрэлтэд суурилсан экстейншиний үйл ажиллагааг сайжруулан хамтын ажиллагааг идэвхижүүлнэ.</p> <p>4.7.Хөдөө аж ахуйн шинэ техник тоног,төхөөрөмжийг орон нутагтаа чадварлаг эзэмших шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэх богино хугацааны сургалтыг зохион байгуулж дадлагын орчинг ногоон тэжээл тариалсан талбайд хийлгүүлэн дадлагажуулж,сургах ажлыг шаталсан байдлаар явуулна.</p>	<p>4.6 Сурталчилгаа болон мэдээллээр хангахын тулд веб хуудас, төслийн танилцуулга, шинэ техник тоног төхөөрөмжийн тухай мэдээлэл бэлдсэн. Хамтын ажиллагааг сайжруулах ажилд идэвхтэй нэгдэж ХХААЯ, НХХААГ, ХААИС зэрэгтэй хамтран ажиллах төлөвлөгөөтэй байгаа.</p> <p>4.7 Хөдөө аж ахуйн их сургуультай байгуулах шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэх богино хугацааны сургалтыг зохион байгуулж дадлагын орчинг ногоон тэжээл тариалсан талбайд хийлгүүлэн дадлагажуулж,сургах зэрэг чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулахааруулсан санал солилцов.</p>
7	<p>Дүгнэлт/ололт, анхаарах асуудлууд/</p>	<p>Төслийн хүрээнд НХХААГ-с зарлагдсан багц тендерүүдийн дагуу дунд оврын тоног төхөөрөмжүүд, хайс хашаа, худаг зэргийг амжилттай хүлээж авсан ба НХХААГ-аас төслийн 500га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын шинэ технологийг нэвтрүүлснээр бэлчээрийн талхигдлыг багасгаж, цөлжилтийг бууруулах бүрэн боломж бүрдэж байна. Дээрх шинэ технологийн дагуу тариалсан олон найрлагад, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өвөл, хаврын улиралд ч шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломж бүрдэнэ.</p> <p>Одоогоор агаараар цахилгааны шугам татах ажил дууссан боловч фермийн барилгын байрлалыг өөрчилсөнтэй холбогдон 520 м цахилгааны утсыг агаараар татах ажлыг гүйцэтгэх шаардлагатай бөгөөд энэ ажилд 40.000.000 төгрөг шаардлагатай байгаа. Мөн төслийн гол бүрэлдэхүүн хэсэг болох олон наст ургамлын үрийн холимгийг Австри улсаас нийлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх болон Австри улсын мэргэжилтэн К.Бухграберийн Монгол улсад томилолтоор 2 удаа ажиллуулах зардал болох нийт 63.200.000 төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.</p>
8.	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	

9.	Төсөл, хөтөлбөрийнхэрэг жилтийнүнэлгээ(Ө өрийнүнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		75%	4	90%	50%	90%	70%
10.	төсөл, хөтөлбөрийнхэрэгжилтийнүнэ лгээ/нэгдсэн үнэлгээ/ЗГХЭГ- ын үнэлгээ/	Нэгдсэнүнэлгээ					
	%					

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА

Д. БАЯНБАТ

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ГТХ-ын МЭРГЭЖИЛТЭН

У.ӨНӨРЖАРГАЛ

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙННЭГЖ ОНӨТҮГ-ын
АГРОНОМИЧ

Г.ЮМЖАВ